

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ : ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1 хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан байна.

1.2 хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

1.3 хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨРӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН ӨССӨН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА.....15

2.1 хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлсэн боловч үр нөлөөг тооцоогүй байна.

2.2 засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөг бодитой тооцоогүй байна

2.3 ХЭДС-ийн орлогын 99.3 хувийг төвлөрүүлсэн ба журмын дагуу зарцуулсан боловч үр нөлөөг тооцоогүй байна.

ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ :	30
ШИЙДВЭР:	31
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	32
ХАВСРАЛТУУД:	34-36

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Товчлол	Тайлбар
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АБДХ	Ажлын байр дэмжих хөтөлбөр
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МБСДС	Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан
МХЭДХ	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОНО	Орон нутгийн онцлог
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СХС	Сум хөгжүүлэх сан
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭДХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Хүснэгт, дүрслэл, зураг , хавсралтын тайлбар

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хөдөлмөр, эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө /сая.төг/	14
Дүрслэл 2	Ажилгүйдлийн дундаж түвшин /улс,аймаг	14
Дүрслэл 3	Ажилгүйдлийн түвшин, түүнд зарцуулсан хөрөнгө	15
Дүрслэл 4	ЖДҮДС-гийн зээлд, хамрагдсан иргэн, ААНБ /тоогоор	17
Дүрслэл 5	Гэрээний хугацаа дууссан болон дуусаагүй санхүүгийн дэмжлэг /хувиар/	21
Дүрслэл 6	ХЭДС-аас 2016-2021 онд олгосон санхүүгийн дэмжлэг, хөтөлбөрөөр /сая.төг/	22
Дүрслэл 7	Нийтийг хамарсан ажлын хүрээнд бий болсон түр ажлын байр, зарцуулсан хөрөнгө, хамрагдсан сумаар	26
Хүснэгт 1	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ	9
Хүснэгт 2	Салбар зөвлөлийн хурлын тоо, урамшуулал	10
Хүснэгт 3	Үндсэн чиглэлд тусгагдсан асуудлууд, тэдгээрийн үнэлгээ	11
Хүснэгт 4	Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үнэлгээ	11
Хүснэгт 5	Дэд хөтөлбөрт хийсэн хяналт шинжилгээний дүгнэлт	11
Хүснэгт 6	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээний тоо мэдээ, тулгалт /хүний тоогоор/	12
Хүснэгт 7	Аймгийн хэмжээнд 15 түүнээс дээш настай ажиллах хүчнээс гадуур хүн амын тоо /хүйсээр/	19
Хүснэгт 8	Аймгийн ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалт /сая.төг/	22
Зураг 1	Есөнбулаг сумын СХС-аас зээл авсан иргэдтэй хийсэн уулзалт	17
Зураг 2	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан , үйл ажиллагаа явуулж байгаа иргэд	26
Хавсралт 1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн ажлын гүйцэтгэл	33
Хавсралт 2	Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системийн тоо мэдээний тулгалт	34
Хавсралт 3	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө	35
Хавсралт 4	СХС-аас зээл авсан үйл ажиллагаа явуулаагүй иргэдийн судалгаа	36
Хавсралт 5	ХЭДС-аас 2016-2021 онд олгосон санхүүгийн дэмжлэг, түүний орлогын төвлөрүүлэлт	37
Хавсралт 6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын нэгтгэл /2016-2021/	38
Хавсралт 7	Сонгон шалгаруулалтад орохоор ирүүлсэн болон шалгарсан ТАХ	39
Хавсралт 8	ХЭДС-аас зориулалт бусаар зарцуулсан иргэдийн судалгаа 2016-2021 он	40
Хавсралт 9	Ажлын байр дэмжих чиглэлээр олгогдсон төсөл хөтөлбөрийн , давхардлын судалгаа	41

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийлээ.
Аудитын зорилт	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Дээрх зорилгын хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: - Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх - Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгасан төсөл, хөтөлбөр зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /хөдөлмөрийн алба/, хөдөлмөрийн биржийн 2016-2021 оны үйл ажиллагааг хамруулна. Аудитын хугацаанд Ковид-19 халдварын цар тахлын үеийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой сумдад хэрэгжсэн ТАХ-г тус сумын СХС-ийн хяналтын зөвлөл, амьжиргаа дэмжих зөвлөлөөр хяналт хийлгүүлэн, баримт мэдээллийг аудитад ашигласан.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817:2020 3Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” MNS 6817:2020 3Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа Хүндрэл бэрхшээл	Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж стандартыг хангуулан, ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитор Н.Гэрэлмаа, аудитор Ц.Сайханжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 11-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 26-аас 30-ний өдөр хүртэл хийж аудитын тайланг 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр баталгаажуулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэв. 1. Аудитын судалгаа, мэдээллийг зарим сумууд хугацаанд үнэн зөв, нотлох баримтаар баталгаажуулан гаргаж ирүүлээгүй. Тухайлбал: Халиун, Жаргалан, Цогт, Шарга сумууд гүйцэтгэлийн үе шатны ажил дуусахаас 1 хоногийн өмнө ирүүлсэн. 2. Аймгийн салбар зөвлөл шинэчлэгдсэнтэй холбоотойгоор 2018, 2019, 2020 оны төлөвлөгөө, тайлан, хурлын тэмдэглэл баримт материал ирүүлээгүй.

Үндсэн мэдээлэл

Говь-Алтай аймагт 2016-2021 онуудад Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, ажлын байр нэмэгдүүлэх, дэмжих чиглэлээр ХЭДС-д 2016 онд 637.5 сая төгрөг, 2017 онд 922.3 сая төгрөг, 2018 онд 1,247.9 сая төгрөг, 2019 онд 1,496.8 сая төгрөг, 2020 онд 1,012.0 сая төгрөг, 2021 онд 1,193.5 сая төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсан байна.

Нийт хэрэгжсэн төсөл 47 хувь Есөнбулаг суманд хэрэгжсэн, үлдсэн төсөл хөтөлбөр нь сумдад хэрэгжсэн байна.

Мөн СХС-аас ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр 2016-2021 онд 917 иргэнд 5,217.4 сая төгрөгийн, ЖДҮДС-аас 2016-2021 онд 23 иргэнд 1,060.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

Цар тахалтай холбоотой ажлын байрыг хадгалах чиглэлээр хөнгөлөлттэй олгосон 3 хувийн хүүтэй зээлийг 2016-2021 онд 172 иргэнд 3,119.2 сая төгрөгийг олгосон байна.

Говь-Алтай аймгийн хэмжээнд 4 дэд хөтөлбөрүүдийг батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД НЬ ҮНДЭСНИЙ УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТТОЙ УЯЛДСАН БАЙНА.

1.1.1 Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийн зорилго, зорилтууд нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 70 дугаар чуулганаар баталсан "Тогтвортой хөгжлийн зорилго-2030"-тай уялдсан байна.

НҮБ-ын Ерөнхий Ассемблей 2015 оны 9 дүгээр сард “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилго”-ыг НҮБ-ын 193 гишүүн орны шийдвэрээр баталсан байна. Шийдвэрт ядуурлыг устгах, байгаль орчноо хамгаалах, хүний тайван амгалан амьдрах эрхийг хангах зэрэг 17 олон улсын хөгжлийн талаарх асуудлыг шийдвэрлэхээр санал болгон дэвшүүлж буй багц зорилтуудаа хамруулжээ. Тус хөгжлийн зорилготой уялдуулан Улсын Их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралтаар “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”¹-ыг баталж, Ерөнхий сайдын 2016 оны 44 дүгээр захирамжаар шалгуур үзүүлэлтүүдийг урьдчилсан байдлаар тодорхойлсон байна.

1.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа хангагдсан байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор МУ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг² 2015 оны 11-р сард баталжээ.

Говь-Алтай аймгийн хувьд аймгийн ИТХ-ын 2016 оны 2/2 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020 оны 11 дүгээр тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2022-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг, жил бүр аймгийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлийг тус тус баталсан байна.

Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 92 дугаар тогтоолоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, салбарын бодлого, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Тогтвортой хөгжил-Түншлэлийн зөвлөл”-ыг байгуулсан боловч үйл ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй байна.

Түүнчлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 46 дугаар тогтоолоор “Ногоон-Алтай-Ногоон ажлын байр хөтөлбөр”, 52 дугаар тогтоолоор “Бүтээлч-Алтайчууд хөтөлбөр”, 53 дугаар тогтоолоор “Алтайн малчин ажлын байр хөтөлбөр”, 54 дүгээр тогтоолоор “Алтайн баялаг-Залуус хөтөлбөр”-ийг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

¹ <https://legalinfo.mn/mn/detail/11725>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11484>

1.1.3 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг хийсэн боловч гарсан үр дүн, зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг аймгийн ЗДТГ, ХХҮГ-аас 2019 онд 18 сум, 2 тосгоны 6 бүлгийн 5442 иргэнийг хамруулан хийсэн. Уг судалгааны хүрээнд “ойрын 3 жилд 1430 ажиллах хүчний эрэлт үүсэх төлөвтэй байна. 2020 онд 891, 2021 онд 325, 2022 онд 214 ажлын байр шаардлагатай” гэсэн дүгнэлтийг хийжээ.

Гэвч иргэн ажил олгогчийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах ажил хангалтгүй хийгдсэн, иргэн ААНБ-ын мэдээллийг үнэн бодитой мэдээллийн санд оруулдаггүй, ХЭДС-гийн арга хэмжээнд хамрагдах иргэний хэрэгцээг тодорхойлоогүй байна гэж үзлээ.

1.1.4 Бодлогын баримт бичгийг боловсруулахад бүх талын оролцоог хангасан эсэхийг нотлох баримтгүй байна.

Аймгийн ИТХ, ЗДТГ, ХХҮГ-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрийг төлөвлөхдөө иргэний нийгмийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, судлаачийн оролцоо, судалгаа тооцооллыг хийсэн эсэх нь тодорхой нотлох баримтгүй байна.

Холбогдох мэргэжилтнээс тодруулахад хөтөлбөрийн төслийг төрийн байгууллагаас боловсруулж төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулан хэлэлцүүлэг хийж баталж байгаа гэх боловч аудитын хугацаанд түүнийг батлах нотлох баримтыг ирүүлээгүй.

1.2 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэлтэй тооцоогүй байна.

Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1-т “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн жилд орон нутагтаа хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, тэдгээрт сан болон дэд сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өмнөх оны 7 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ” заасны дагуу ХЭДС-гийн санхүүжилтийг улсын төсвөөс 100 хувь санхүүжүүлэхээр 2016 онд 1,370.9 сая төгрөгөөр, 2017 онд 1,360.9 сая төгрөгөөр, 2018 онд 1,349.7 сая төгрөг, 2019 онд 1,549.8 сая төгрөгөөр, 2020 онд 1,309.3 сая төгрөгөөр, 2021 онд 1,150.6 сая төгрөгөөр нийт 8,091.0 сая төгрөгөөр тооцож, төсвийн төслийг хугацаанд нь албан тоотын хамт хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, тоо мэдээлэл, судалгаанд суурилаагүй, зөвхөн өмнөх оны гүйцэтгэл дээр суурилан төлөвлөлтийг хийжээ. Тооцож хүргүүлсэн төсвийн саналын дунджаар 62 хувь батлагдсан байна.

1.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, тусгаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлд санг 7 эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан. Гэвч орон нутгийн дэд сангийн хувьд ганц улсын төсвөөс хуваарилан санхүүжүүлж эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаагүй байна. Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 2 дугаар тогтоол “аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5-д “тухайн орон нутгийн хөдөлмөр

эрхлэлт дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудал хэлэлцэж зөвлөмж гаргах, сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт гаргах” гэж заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэлээ.

Мөн санд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй, холбогдох тооцоо судалгаа байхгүй тул аудитын баг Нийгмийн даатгалын хэлтсээс бааз суурийг авч аудитад ашигласан болно.

Аудитаар ХБИ ажиллуулаагүйн төлбөрт 2019 онд 3.8 сая төгрөг, 2020 онд 3.5 сая төгрөг, 2021 онд 171.5 сая төгрөг нийт 178.9 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна гэж үзлээ .

1.1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох санхүүгийн нөөцийг сумдад журмын дагуу хуваарилаагүй байна.

Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 2 дугаар тогтоолоор “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.7-дахь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдах сум хорооны хуваарийг тухайн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, орон нутгийн хүн ам, ажилгүйдлийн түвшин зэргийг харгалзан батлах, бодлого чиглэл гаргах” заалтын дагуу салбар зөвлөлөөс санхүүгийн нөөцийг хуваарилах асуудлыг 2016-2021 онд огт хэлэлцээгүй байна.

Харин ХХҮГ-аас сумдад санхүүгийн дэмжлэгийг жигд тэгш хүртээмжтэй байх зарчмыг баримтлан сумдад хуваарилсан байна. Сумдад хуваарилсан санхүүгийн дэмжлэгийг ажилгүйдлийн түвшинтэй харьцуулан үзэхэд: Тайшир, Эрдэнэ, Жаргалан сумдад илүү хуваарилжээ. Гэтэл Тайшир, Эрдэнэ, Жаргалан сумдын ажилгүйдлийн түвшин аймгийн хэмжээнд хамгийн бага байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээс харахад ажилгүйдлийн түвшин Есөнбулаг суманд хамгийн өндөр 10.9 хувьтай, Бугат, Шарга сумдад тус тус 3.1 хувьтай байгаа нь улсын дүнгээс 4.4- 12.2 хувиар илүү байна. Харин Цогт суманд ажилгүйдлийн түвшин 0.8 хувьтай гарсан нь хамгийн бага байна.

1.2 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө уялдсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд тухайн салбарын сайд, тухайн салбарын төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар удирдана” гэж заажээ. Аймгийн хэмжээнд тус чиг үүргийг Засаг дарга, ХХҮГ хариуцахаар байна.

Аймгийн Засаг дарга нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай жил бүр гэрээ байгуулан, түүнд нийцүүлэн аймгийн ХХҮГ-ын дарга нь ХХҮЕГ-ын дарга, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр 2016-2021 онд 120 арга хэмжээг тусгасан байх бөгөөд хэрэгжилтийн хувийг дунджаар авч үзэхэд 87.11 хувьтай байна.

Хүснэгт №1: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ³

д/д	Огноо	Байгууллагын төлөвлөгөөний нийт заалтын тоо	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байр нэмэгдүүлэх заалтын тоо	Эзлэх хувь	Дээд шатны удирдлагаас ажил дүгнэсэн үнэлгээ
1	2016	31	20	64%	83.53
2	2017	17	8	47%	86.43
3	2018	63	36	57%	80.09
4	2019	59	36	61%	91.00
5	2020	35	8	22%	92.70
6	2021	46	12	26%	88.91
Нийт		251	120	47%	87.11

1.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ бүс, орон нутгийн онцлогт тохирсон зохицуулалтын арга хэмжээг авч ажиллахгүй байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 8 хөтөлбөр, 2017-2021 онд 7 хөтөлбөр хэрэгжсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ алслагдсан болон эдийн засгийн сул хөгжилтэй бүс, орон нутагт зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийг баримтлан шинээр дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- 2021 онд цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр “Start up” хөтөлбөр
- Орон нутгийн онцлог тохирсон зорилтот төсөл хөтөлбөр
- Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр -Дэлхийн банк

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоол “орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл батлах тухай”-ын 6 дугаар зүйлийн 6.5-д “аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төслийн ерөнхий шаардлага, шалгуурын дагуу орон нутгийнхаа онцлог хэрэгцээ, хүн ам, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдэд тулгуурлан зээлийн санхүүжилтийн тэргүүлэх чиглэл, төсөлд тавигдах нэмэлт шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлно” гэж заасан.

Гэвч хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөс орон нутгийн онцлогт тохирсон төсөл хөтөлбөрийн журам, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ёстой боловч энэ талаар ажил хийгдээгүй байна.

1.2.3 Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 2 дугаар тогтоолоор “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг баталсан. Уг дүрмээр аймгийн салбар зөвлөл нь 8 эрх, 9 чиг үүрэгтэй байна. Салбар зөвлөлийг дүрэмд зааснаар салбарын төлөөллийг оролцуулан 2016 онд 8 хүний, 2017-2018 онд 9 хүний, 2019 онд 10 хүний, 2020-2021 онд 7 хүний бүрэлдэхүүнтэй сонгосон байна.

Тус зөвлөлийн 2017, 2020, 2021 оны ажлын төлөвлөгөө, тайлан, хурлын тэмдэглэл ирүүлсэн бөгөөд 2016, 2018, 2019 оны хурлын тэмдэглэлийг файлаар ирүүлсэн.

Хүснэгт № 2: Салбар зөвлөлийн эрх, үүргийн хэрэгжилт⁴

Огноо	Эрхийн хэрэгжилт	Үүргийн хэрэгжилт	Авсан урамшуулал	Хурлын тоо
2016-2021	25%	33%	18.8 сая	18 удаа

³ Эх сурвалж: Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2016-2021 оны үйл ажиллагааны тайлан.

⁴ Эх сурвалж: Салбар зөвлөлийн ажлын тайлангаас.

Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэхээс гадна дараах 2 ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

- 2019 онд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн гишүүнтэй хамтран ХЭДС-аас олгосон төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцан Тайшир, Есөнбулаг сумдад ажилласан байна.
- Мөн 2021 онд нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгж шалгаруулах аяныг зарласан боловч аяны оролцогч хангалтгүй гэх үндэслэлээр хэрэгжээгүй байна.

Гэвч тус зөвлөл нь үндсэн эрх, үүргээ

- Төрийн бодлого шийдвэрийг орон нутагт зохион байгуулах
- ОНО-той хөтөлбөр төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг удирдан зохицуулах, биелэлтэд хяналт тавих,
- Сангийн төсвийг бүрдүүлэх, зарцуулах, хуваарилах асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргах,
- Хяналтын тайлан мэдээ, дотоод хяналт болон хөндлөнгийн байгууллагаас хийсэн хяналт шалгалт, үнэлгээний дүн, санхүүгийн тайланг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах
- Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах
- Төрийн бусад байгууллагатай харилцаа хамтын уялдаа холбоотой ажиллах
- Үндэсний зөвлөлөөс гаргасан удирдамж, зөвлөмжийг баримтлан ажиллах
- Сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, холбогдох газарт уламжлах зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хангалтгүй зохион байгуулсан байна гэж үзлээ.

Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2016, 2018-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ажлын тайлан, хурлын тэмдэглэл зэрэг нотлох баримтгүй 18.8 сая төгрөгийн урамшуулал бусад зардлыг санхүүжүүлсэн, салбар зөвлөлөөс авч хэрэгжүүлсэн ажил, хяналт хангалтгүй байна.

1.2.4 Бодлогын хэрэгжилтийг бодитой тайлагнаагүй, 2 дэд хөтөлбөрт хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

“Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1 дүгээр зүйлийн 1.5-т хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн, 500-аас доошгүй байнгын ажлын байрыг бий болгох чиглэлээр 5 хөтөлбөрийг тусгасан байх бөгөөд хэрэгжилтийг 75 хувьтай гэж дүгнэжээ. Аудитаар давтан тооцож үзэхэд 63.3 хувьтай байна.

Харин жил бүрийн үндсэн чиглэлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлын 2017-2021 оны дундаж хэрэгжилтийн давтан тооцож үзэхэд 79.4 хувьтай байна.

Хүснэгт 3: Үндсэн чиглэлд тусгагдсан асуудлууд, тэдгээрийн үнэлгээ

Огноо	Үнэлгээ	Давтан үнэлгээ
2017	91.67	82.11
2018	89.11	89.11
2019	84.0	84.0
2020	77.5	60.78
2021	90.0	85.63
Дундаж	87.0	79.4

Аудитаар аймгийн ИТХ-аар батлагдсан 4 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг авч үзэхэд 73.62 хувьтай дүгнэгдэж байна. Шалтгааныг тодруулж үзэхэд бодит байдалд тус хөтөлбөрүүд нь хэрэгжсэн байх боловч аймгийн ЗДТГ, ХХҮГ болон салбарын байгууллагууд нь уялдаа

холбоогүй, түүнийг тайлагнах ажил хангалтгүй, цаасан суурьт нотлох баримтыг архивын нэгж болгодоггүй, мэдээллийн сан, баазгүй, албан тушаалтан нарын хариуцлагагүй үйлдлээс шалтгаалж байна.

Хүснэгт № 4: Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үнэлгээ⁵

Хөтөлбөр	Үнэлгээ
Ногоон-Алтай-Ногоон ажлын байр хөтөлбөр	64.83
Бүтээлч-Алтайчууд хөтөлбөр	93.57
Алтайн малчин ажлын байр хөтөлбөр	73.08
Алтайн баялаг-Залуус хөтөлбөр	63.02
Дундаж	73.62

Мөн аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2020 онд 2 дэд хөтөлбөрт мониторинг хийж дүгнэлт гарсан байна.

Хүснэгт № 5: Хяналт шинжилгээний үнэлгээний дүгнэлт⁶

д/д	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан огноо	Хэрэгжих хугацаа	Огноо	Хяналт шинжилгээ үнэлгээний дүгнэлт
1	Алтайн баялаг залуус	5/31/2017	2017-2020	2020	81.42
2	Бүтээлч-Алтайчууд	5/31/2017	2017-2020	2020	93.57

Харин аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын Хяналт, мониторингийн газраас 2020 онд 1 удаа, аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2017, 2019 онд 2 удаа, аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017, 2018 онд 2 удаа, Төрийн аудитын байгууллагаас жил бүр хяналт шалгалтыг гүйцэтгэж алдаа зөрчилд шийдвэр хүргүүлж хэрэгжилтийг хангуулжээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ДҮГНЭЛТ: ТӨРӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН ӨССӨН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА.

2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлсэн боловч үр нөлөөг тооцоогүй байна.

2.1.1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч байнгын ажлын байр бий болсон эсэх нь тодорхой бус байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтад заасны дагуу “ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах” хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамруулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг 2011 онд шинэчлэн найруулж, 2012, 2014, 2015, 2016, 2017 онуудад нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Хөдөлмөрийн сайд, БСШУС-ын хамтарсан 2016 оны А165/А266 дугаар тушаалаар “Ажил мэргэжлийн чиг баримжааг хөгжүүлэх чиглэл /2016-2024/-ийг баталсан байна. Уг чиглэл 2 үе шаттай хэрэгжиж байна.

Аймгийн хэмжээнд ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөөг ганцаарчилсан иргэнд 2016-2021 онд 2045 иргэнд, бүлгээр 4114 иргэнд, ажилд зуучлах үйлчилгээг 3761 иргэнд үзүүлсэн гэж мэдээлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /ганцаарчилсан/ үйлчилгээг 13 хувьтай, ажилд зуучлах үйлчилгээг 72 хувьтай хэрэгжүүлж байсан бол 2017-2021 онд төлөвлөгөөг давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байгаа нь 1

⁵ Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын 2022.04.12-ны өдрийн 7/427 дугаартай албан бичгийн хавсралтаас.

⁶ Эх сурвалж: Аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ажлын тайлан.

иргэнд ногдох норматив зардлыг хэмнэн, олон хүмүүс хамруулсан нь төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулсан сайшаалтай боловч тухайн ажилд зуучилсан иргэн байнгын ажлын байраар хангагдсан эсэх, зөвлөгөө мэдээлэл авсан иргэдийн хэдэн хувь нь ажилтай болсон эсэх талаар хөтөлбөрийн үр дүнг тооцох тал дээр хангалтгүй ажилласан байна.

Аудитаар архивын баримтыг нэгдсэн мэдээллийн системтэй тулгаж үзэхэд 377 иргэнд зөвлөгөө, мэдээллийг илүү өгч зуучилсан байна. /дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү./

Хүснэгт № 6: Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээний тоо мэдээ, тулгалт /хүний тоогоор/

Огноо	Төрөл	2016	2017	2018	2019	2020	2021	дүн
Тайла нгаар	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх/ ганцаарчилсан/	65	352	488	446	395	299	2,045
	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /бүлгээр/	1,237	560	765	1,002	-	550	4,114
	Ажилд зуучлах үйлчилгээ	577	915	683	583	572	431	3,761
Аудит аар	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх/ ганцаарчилсан/	65	352	558	446	395	299	2,115
	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /бүлгээр/	1,274	560	937	1,099	-	550	4,420
	Ажилд зуучлах үйлчилгээ	577	916	683	583	572	431	3,762
Зөрүү	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх/ ганцаарчилсан/	-	-	(70)	-	-	-	(70)
	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /бүлгээр/	(37)	-	(172)	(97)	-	-	(306)
	Ажилд зуучлах үйлчилгээ	-	(1)	-	-	-	-	(1)

Системийн мэдээлэл анхан шатны архивын баримттай тулгаж үзэхэд ихээхэн зөрүүтэй байгаа нь мэдээлэл үнэн зөв, бодитой бус байгааг илтгэж байна.

Ажилд зуучлах үйлчилгээний хувьд 2016-2021 онд нийт 3765 ажлын байр бий болсноос байнгын ажлын байр 2602 буюу 69.1 хувь, түр, улирлын чанартай ажлын байр 1163 буюу 30.9 хувийг эзэлж байна. Гэвч байнгын ажлын байр бий болсон нь бодитоор нотлогдохгүй, судалгаа мэдээлэл байсангүй.

2.1.2 Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн хөгжүүлэлт хангалтгүй, бүртгэл, тоо мэдээ бодитой бус, зөрүүтэй бөгөөд уг мэдээ мэдээллийг Монгол Улсын хэмжээнд ашиглаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын болон ажил олоход хүндрэлтэй иргэний талаарх бүртгэл, мэдээллийг нэгтгэж, хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулна” гэж заасны дагуу программд хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем LMIS программд тоо мэдээллийг оруулдаг байна. Уг программыг үйл ажиллагаандаа 2013 оноос хойш ашиглаж

байгаа программтай холбоотой саналыг тухай бүр хүргүүлсэн боловч хөгжүүлэлт сайжруулалт огт хийгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсвийн, гадаадын зээл тусламжийн, хувийн хэвшлийн болон бусад эх үүсвэрээс шинээр бий болсон ажлын байранд ажиллаж буй иргэдийн судалгааг, дэлгэрэнгүй тайлан мэдээтэй тулгахад 2017 онд 173, 2018 онд 170, 2019 онд 192, 2020 онд 62, 2021 онд 38 иргэн нийт 559-ээр зөрүүтэй байна. /дэлгэрэнгүйг хавсралт №2-аас үзнэ үү/

Аудитаар LMIS программын мэдээллийг хөрвүүлэн ХЭДС-аас төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн нэрсийг тулгахад төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэний нэр тухайн программд байхгүй байсан бөгөөд нийт дүнгээр тулгалт хийхэд 2016-2021 онд 2677 ажлын байр шинээр бий болсноор программд бүртгэсэн бол бодитоор 507 ажлын байр шинээр бий болсон ба 20 хувийг эзэлж байна.

Нэгдсэн бүртгэл мэдээллийн системд 2016 онд 150 иргэний мэдээллийн эх үүсвэрийг сонгоогүй оруулсан, өөр аймаг, дүүргийн 56 иргэний мэдээлэл бүртгэгдсэн байна. Тухайлбал: 2016 онд Төв аймгийн Аргалант сумын 1, Мөнгөнморьт сумын 1, 2017 онд Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн 1, Дархан-Уул аймгийн Дархан сумын 1, Дорноговийн Замын-Үүд 1 гэх мэт нийт 56 иргэн бүртгэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний хүрээнд хийсэн бүртгэлтэй ажилгүй иргэн, шинээр бий болсон ажлын байранд ажиллаж буй иргэдийн тайлангийн нэгтгэлийг, статистик мэдээллийн нэгдсэн сангийн /www.1212.mn/ мэдээлэлтэй тулгахад зөрүүгүй байлаа.

Бүртгэл мэдээллийн сүлжээний зардалд 2016-2021 онд зардалд 28.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Харин 2022 онд ejob.gov.mn цахим системийн нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

2.1.3 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийг тайлагнасан боловч үр ашгийг бодитой тооцоогүй байна.


Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнээс ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх/ ганцаарчилсан, бүлгээр/, ажилд зуучлах үйлчилгээнүүдэд 2016-2021 онд нийт 57.3 сая төгрөгийг зарцуулсан байна. /дэлгэрэнгүйг хавсралт №3-аас үзнэ үү/

- Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /ганцаарчилсан/ үйлчилгээнд 2016 онд хөрөнгө зарцуулаагүй, 2017 онд 1.2 сая төгрөг, 2018 онд 5.1 сая төгрөг, 2019 онд 2.4 сая төгрөг, 2020 онд 1.8 сая төгрөг, 2021 онд 2.7 сая төгрөг нийт 13.3 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /бүлгээр/ 2016 онд 10.3 сая төгрөг, 2017 онд 3.1 сая төгрөг, 2018 онд 4.6 сая төгрөг, 2019 онд 5.9 сая төгрөг, 2020 онд хөрөнгө зарцуулаагүй, 2021 онд 3.3 сая төгрөг нийт 27.3 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Ажилд зуучлах үйлчилгээнд 2016 онд 2.1 сая төгрөг, 2017 онд 1.9 сая төгрөг, 2018 онд 2.3 сая төгрөг, 2019 онд 6.7 сая төгрөг, 2020 онд 2.1 сая төгрөг, 2021 онд 1.3 сая төгрөг нийт 16.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх/ ганцаарчилсан, бүлгээр/, ажилд зуучлах үйлчилгээний зардалд танилцуулга, тараах материал гарын авлага хэвлүүлэх, цайны материал, дэвтэр бал худалдан авах зэрэг багтсан байна. Нийтлэг үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийг үнэн зөв тайлагнасан боловч үр ашгийг тооцож гаргаагүй байна.

Нэгдсэн системд тусгасан мэдээний дагуу авч үзэхэд 2016-2021 онд 57.3 сая төгрөгийг зарцуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулах жишиг зардлын хэмжээг ХНХС-ын тушаалаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын хэмжээг бүлгээр 0.006 сая төгрөг, ганцаарчилсан 0.012 сая төгрөгөөр тогтоосон ба уг зардлын дээд хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр зарцуулсан байна.



Дүрслэл № 1: Хөдөлмөр, эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө⁷ /сая.төг/

2.2 Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөг бодитой тооцоогүй байна.

2.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр арилжааны банкаар дамжин олгогдсон төсөл хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 02 дугаар “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр батлах тухай” тогтоолоор хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Тухайн хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээл нь Арилжааны банкаар дамжин олгогдож байгаа тул зээлийн судалгаа, хяналт үр дүнтэй байна гэж үзлээ.

Уг хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр ХЭДС-д дараах хяналтын зардал орж ирсэн. Үүнд:

- Хөтөлбөрийн хүрээнд 2020 онд 12.2 сая төгрөгийн дэмжлэг авч, 1.0 сая төгрөгийг зээлийн өмнөх сургалтын арга хэмжээг 89 иргэнд зохион байгуулан, үлдэгдэл 11.1 сая төгрөгийг ХХҮЕГ-ын данс руу буцаан төвлөрүүлсэн байна.
- Хөтөлбөрийн хүрээнд 2021 онд 11.6 сая төгрөгийн дэмжлэг авч, зээлийн дараах сургалтын арга хэмжээг 32 иргэнд зохион байгуулан, 1.0 сая төгрөгийг мэдээлэл түгээх, сурталчлах арга хэмжээнд, 1.5 сая төгрөгийг хөтөлбөрийн хяналт үнэлгээнд зарцуулж, 1.4 сая төгрөгийг ХХҮЕГ-т буцаан төвлөрүүлжээ.

Дээрх гадаадын тусламжийн санхүүжилтийн талаарх тайлан мэдээ, зарцуулалтын баримт, материалыг тухай бүр Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газар хүргүүлдэг байна. Төсөл хөтөлбөрт хамрагдсан 1 зээлдэгч Хөхморьт суманд, бусад 31 зээлдэгч нь Есөнбулаг суманд үйл ажиллагаагаа явуулж байна.

2.2.2 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хэлэлцээгүй, ажлын байрны мэдээлэл байхгүй, мониторингийн хяналтаар зөвхөн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн талаар тайланд тусгагдсан байна.

Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан. Уг бодлогод 2 үе шаттайгаар 2016-2025 онд

⁷ Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлан


хэрэгжүүлэхээр 5 төрлийн үйл ажиллагааг төлөвлөж оруулсан байна. Аймгийн 2016-2021 оны ажилгүйдлийн түвшинг улсын дундажтай харьцуулахад 2019 оноос хойш улсын дунджаас өндөр байна.

Дүрслэл № 2: Ажилгүйдлийн түвшин⁸ /улс,аймаг/



Энэ нь 2020 онд улсын дундаж 3 хувиар буурч 7 болсон байхад аймгийн дундаж өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл № 3: Ажилгүйдлийн түвшин, зарцуулсан хөрөнгө⁹



Мөн аймгийн ажилгүйдлийн түвшинг зарцуулсан хөрөнгөтэй харьцуулан үзвэл 2019 онд хамгийн өндөр буюу 1,496.6 сая төгрөгийн зардал гаргасан боловч, ажилгүйдлийн түвшин өмнөх онуудаас эрс нэмэгдсэн байна. Энэ нь цар тахалтай холбоотойгоор тус сангийн хөрөнгө үр нөлөөгүй зарцуулагдсан байж болохыг ажилгүйдлийн түвшний өсөлтөөс харж болно.

ЖДҮД, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр улсын ЖДҮДС, аймгийн ЖДҮДС, сумдын СХС-гаас хөнгөлөлттэй зээлийг олгож, ажлын байрыг дэмжсэн байна. Уг төсөл хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн эсэхийг аудитаар үнэлж дүгнэлээ.

СХС: Тус сангаас 2011 оноос хойш сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор олгож эхэлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2016-2021 онд нийт 962 иргэнд 5,603.4 сая төгрөгийн зээл олгосноос, хүүгийн төлбөрт 324.5 сая төгрөгийг, нэмэгдүүлсэн хүү алдангийн төлбөрт 66.8 сая төгрөгийг, нийт 5,994.5 сая төгрөгийн төлбөрийг төвлөрүүлэхээр байна. Төвлөрүүлэх орлогоос 2,429.9 сая төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдэл 3,564.8 сая төгрөг байгаагаас гэрээт хугацаанд 1,115.7 сая төгрөг төлөгдөөгүй байна.

Манай аймгийн хувьд сумдын СХС-гийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар төлөгдөөгүй зээлийн үлдэгдэлд төлбөрийн акт тогтоож, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

СХС-гийн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт эрсдэлгүй тул тухайн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэд үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулж зээлийг зориулалтын дагуу ашиглаж

⁸ Эх сурвалж: Хөдөлмөрийн салбарын танилцуулга 2020 он

⁹ Эх сурвалж: Хөдөлмөрийн салбарын танилцуулга 2020 он

буй эсэх, шинээр ажлын байр бий болсон эсэхийг үзлээ. /дэлгэрэнгүйг хавсралт №4-ээс үзнэ үү/

- Аудитад хамрагдсан 962 төсөл хөтөлбөрөөс 8 төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулах комиссоор хэлэлцүүлээгүй, шууд санхүүжүүлж зээл олгосон байна. Тухайлбал: Алтай-1, Дарив-2, Цээл-5 иргэн байна.
- Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд сумдын СХС-гийн хяналтын зөвлөлтэй хамтран ажиллан, 962 төсөл хөтөлбөрөөс 257 төсөл хөтөлбөрийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төсөлд заасан 546 ажлын байрыг бий болгоогүй байна гэж дүгнэлээ. Есөнбулаг сумын СХС-гийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын алба 2021 онд хяналт шалгалт хийсэн байна. уг шалгалтаар 61 зээлдэгчийн үйл ажиллагаатай танилцан, 7 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Зураг №1: Есөнбулаг сумын СХС-аас зээл авсан иргэдтэй хийсэн уулзалт



Есөнбулаг сумын СХС-аас 2016-2021 онд 81 иргэн, ААНБ зээл авсан иргэдтэй нээлттэй уулзалт, хэлэлцүүлэг хийлээ. Уг хэлэлцүүлгийн үеэр иргэд, олон нийт сантай холбоотой дараах санал, хүсэлтүүдийг дэвшүүлж байсан.

- Хүссэн зээлээ авахаар өргөдөл өгөхөөр анхны саналаас хасдаг учраас төсөл хөтөлбөрт заасан үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байр бий болгож чаддаггүй
- Зээлийн хэмжээ бага байдгаас хүн авч ажиллуулахад цалингаа нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүйгээр авах сонирхолтой байдаг
- Зээл олголтын мэдээ, мэдээлэл дутмаг, мэдээ мэдээллийг ойр дотно хүнээсээ авдаг, зээл авахаар хүсэлт өгөөд 1-2 жил болж байж шийдэгддэг.

ЖДҮДС: Аймгийн ЖДҮДС-аас 2015-2021 онд 1,060.0 сая төгрөгийн зээлийг 23 иргэн, ААНБ-д олгосон байна.

Төрийн аудитын байгууллагаас жил бүрийн аймгийн ЖДҮДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг орон нутгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн санхүүгийн тайлангаар үзэж, холбогдох шийдвэрийг гаргасан байна. Тухайлбал: 2016-2021 онд 614.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, зарим шийдвэр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжсэн байна.

Тус сангаас 2015-2016 онд 6 иргэн, ААНБ-д олгосон 380.0 сая төгрөгийн зээлийг хүү, алдангийн төлбөр тооцолгүйгээр ашиглуулсан боловч ажлын байр нэмэгдүүлсэн нь тодорхой бус байна.

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа иргэн, ААНБ-ууд нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа боловч хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинээр ажлын байр нэмэгдүүлсэн эсэх нь тодорхой бус байна. Учир нь түр болон байнгын ажилтан авч ажиллуулж байгаа гэх боловч, тэдгээрийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй байна.



Дүрслэл №4: ЖДҮДС-ийн зээлд хамрагдсан иргэн, ААНБ¹⁰ /тоогоор/

Сангуудын зээлийн давхардлын талаар:

Аудитаар 2016-2021 онд ХЭДС, ЖДҮДС, СХС, жижиг зээлд хамрагдсан иргэн, ААНБ-ын зээлийн давхардлын судалгааг хийсэн. Уг судалгаагаар 1 төслөөр сангуудаас давхар зээл авсан, зээлийн өр төлбөртэй иргэнд өөр сангаас дахин зээл олгосон, 1 онд 2 сангаас зэрэг зээл авсан, 1 үйл ажиллагаа явуулж байгаа газрын нэрээр 2 иргэн давхар зээл авсан байна. Тухайлбал:

- ❖ Нэг иргэнд 2018 онд арилжааны банкнаас 3 хувийн хүүтэй 20.0 сая төгрөгийн зээл, 2019 онд ХЭДС-аас 15.0 сая төгрөг, 2020 онд улсын ЖДҮС-аас 138.0 сая төгрөгийн зээлд давхар хамруулсан байна.
- ❖ Нэг иргэнд 1 төслөөр үйл ажиллагаа явуулахаар СХС-аас 2018 онд 30.0 сая төгрөг, 2019 онд ХЭДС-ээс 15.0 сая төгрөгийн зээл авчээ.
- ❖ Нэг иргэнд 1 төслөөр үйл ажиллагаа явуулахаар 2017 онд аймгийн ЖДҮДС-аас 40.0 сая төгрөгийн зээл авсан боловч уг төслөөр өөр иргэн дахин 2018 онд ХЭДС-аас 10.0 сая төгрөгийн зээл авчээ.
- ❖ 2016-2021 онд 7 иргэн 1 төслөөр СХС болон ХЭДС-ийн зээлд давхар хамрагдсан байна.

Зээлийн мэдээллийн нэгдсэн санд ХЭДС, ЖДҮДС-ийн мэдээллийг оруулаагүйгээс зээлийн давхардал орон нутагт бий болсоор байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр олгож байгаа төсөл хөтөлбөрүүдийг бодитой үнэ цэнийг үнэлж, үйл ажиллагаа явуулж болохуйц хэмжээний зээлийг 1 эх үүсвэрээс олгох зайлшгүй шаардлага үүссэн байна.

Энэ нь нэг талаас иргэдийн дунд мэдээ мэдээлэл хомс байдгаас төсөл хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байгааг харуулж байна. Нөгөө талаас төсөл хөтөлбөрийг үнэлэх, давхардуулан олгохгүй байх хууль эрх зүйн орчин дутмаг байгаагаас шалтгаалж төсөл хэрэгжихгүй байх, давхардуулан авсан байна.

Хяналт мониторингийн талаар:

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 6.3 дахь заалтын дагуу ХХҮЕГ-ын хяналт, мониторингийн газраас 2020 онд хяналт хийсэн байна. Уг хяналт шалгалтаар 6 заалт зөвлөмж өгсөн байна. Үүнд:

¹⁰ Эх сурвалж: ЖДҮДС-ийн санхүүгийн тайлан

- Төсөл, хөтөлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд багтаан төлүүлэх
- Төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулахдаа зохих хууль журмын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй зохион байгуулж байх
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын болон гүйцэтгэлийн хяналтыг тогтмол хийж, үр дүн үр нөлөөг тооцон хэрэгжээгүй төсөл арга хэмжээг буцаан татаж сангийн хөрөнгийн үр ашигтай байдлыг сайжруулахад анхаарч ажиллах
- Сангийн хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулахгүй байх
- Санхүүгийн анхан шатны баримт дутуу гүйлгээ хийхгүй байх
- Энэ тайланд дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч 2021 оны 01 дүгээр сарын 30-ны дотор тайланд дурдагдсан зөрчлийг арилган, хэрэгжүүлж биелэлтийг ирүүлэх.

Дээрх хяналт шалгалтаар төсөл хөтөлбөрийн хэрэгжилт буюу үйл ажиллагаатай танилцаагүй, үр дүнг тооцоогүй, зөвхөн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт санхүүжилтийн талаар тайланд дурдсан байна.

ХХҮГ-аас хяналт шалгалтын мөрөөр төлөвлөгөө боловсруулан, сумдад ажиллан, хариуг 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн боловч үр дүн гараагүй, шийдвэрийг хугацаанд нь хүргүүлээгүй байна.

Дотоод хяналтын талаар:

Аймгийн ХЭДС-ийн 2016-2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймгийн ХХҮГ-ын дотоод хяналт жил бүр хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан батлуулан, ажилласан байна. Тус хяналт шалгалтаар дараах заавар зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд:

- Хөтөлбөрт шаардлага нийцсэн малчин иргэдийг хамруулах
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын арга хэмжээнд хамрагдсан иргэдийг ажлын байранд зуучлах
- Тайлан, тоо мэдээллүүдийг зөрүүлэхгүй байх
- Тайлан өгөхгүй байгаа, холбогдож болохгүй байгаа иргэдэд гэрээний дагуу зохих арга хэмжээ авч ажиллах
- Жижиг зээл авсан иргэдийн судалгааг гаргаж, зээл авсан аваагүйгээр ялгах
- Төсөл хөтөлбөрийн зориулалтын дагуу ашиглаагүй бол ашиглах мэдэгдэл хүргүүлэх
- Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулж ажиллах

Аймгийн МХГ, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт аудитын албанаас 2017 онд хяналт хийж, дараах зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлсэн байна.

- Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутгийн төсвөөс ХЭДС-д хуваарилах хөрөнгийг ИТХ-д санал оруулж, төсөвт тусгах, санхүүгийн санхүүгийн тайланг гаргах, орлого зарлагын байдалд хяналт тавьж, үр дүнг тооцож, хуульд заасан бүрэн эрх үүргээ, хангаж ажиллах
- Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй, хангалтгүй ажилласан
- ААНБ, иргэний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, олон нийтэд ил тод мэдээлж, иргэн ажил олгогчийг хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдээлэл авах боломжоор хангаж ажиллах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг төвлөрүүлэх
- Сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг үр дүнтэй зохион байгуулах

- Төсөл, хөтөлбөр хариуцсан албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг нэмэгдүүлж, хөтөлбөрийг үр дүнтэй зохион байгуулж ажиллах

Дээрх хяналт шалгалтуудаар илэрсэн зөрчил арилаагүй, аудитаар дахин илэрч байгаа нь хяналт шалгалтын мөрөөр ямар нэгэн дорвитой арга хэмжээ авч ажиллаагүй, хяналт үр дүнгүй, төслийн үр дүн, үр нөлөөг тооцож үнэлээгүй байгааг нотолж байна.

2.2.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар зохих үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Засгийн газрын 2016 оны 320 дугаар тушаал “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж заасан байна. Дээрх бодлогын хэрэгжилтийг хангуулахаар 2016-2021 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлсэн боловч эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлээгүй орхигдуулсан байна.

Хүснэгт № 7: Аймгийн хэмжээнд 15 түүнээс дээш настай ажиллах хүчнээс гадуур хүн амын тоо /хүйсээр¹¹

Хүйс	2010 он		2020 он	
	тоо	хувь	тоо	хувь
Эрэгтэй	5638	41%	5880	42%
Эмэгтэй	8058	59%	7972	58%
Нийт дүн	13696	100%	13852	100%

Хүн ам, орон сууцны тооллогын 2020 оны нэгдсэн дүн мэдээллээс харахад ажиллах хүчнээс гадуурх хүн амын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь сүүлийн 10 жилд эрэгтэйчүүдээс өндөр байна. Энэ нь эмэгтэйчүүдийн хувьд

ажилгүйдэл өндөр байгааг харуулж байна. Мөн дээрх тооллогоор ажилгүйдлийн түвшинг насны ангилал, хүйсээр харахад өнгөрсөн 10 жилийн хугацаанд ажилгүйдлийн түвшин аймгийн хэмжээнд буурсан байгаа боловч, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Харин 50 түүнээс дээш насанд ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн нь ажил олгогчдын зүгээс шинээр ажлын байранд насны хязгаар заадаг, түүнчлэн энэ насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хөтөлбөр дутмаг байгаатай холбоотой байж болох юм.

2.3 ХЭДС-ийн орлогын 99.3 хувийг төвлөрүүлсэн ба журмын дагуу зарцуулсан боловч үр нөлөөг тооцоогүй байна.

2.3.1. ХЭДС-ийн орлогын 99.3 хувийг бүрэн төвлөрүүлсэн байна.

ХЭДС-гийн эх үүсвэрийг улсын төсвөөс хуваарилан санхүүжүүлж байна. Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгүүдийн эргэн төлөлтийг ХЭДС-ийн дэд сангаас төв дансанд тухай бүр нь буцаан төвлөрүүлж байна. Тухайлбал: 2016 онд 67.5 сая төгрөг, 2017 онд 201.3 сая төгрөг, 2018 онд 361.5 сая төгрөг, 2019 онд 374.9 сая төгрөг, 2020 онд 375.1 сая төгрөг, 2021 онд 556.1 сая төгрөг нийт 1,936.4 сая төгрөгийг Төрийн сангийн 100900037010 дансанд төвлөрүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд ХЭДС-аас 6 хөтөлбөр хэрэгжсэн бөгөөд олгосон санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөр тус бүрээр ангилж, эргэн төлөлтийг тооцлоо. /дэлгэрэнгүйг хавсралт № 5-аас үзнэ үү/


- АБДХ-ээр 2016-2021 онд 310 иргэнд 878.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос 80.9 сая төгрөгийг 2016 онд хөнгөлж, 524.6 сая төгрөгийг төвлөрүүлж,

¹¹ Эх сурвалж: Хүн ам, орон сууцны тооллогын 2020 оны нэгдсэн дүн Говь-Алтай аймаг

272.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, төлөгдөөгүй байна. Үүнээс гэрээний хугацаа дуусаагүй 267.3 сая төгрөг, хугацаа хэтэрч хуулийн байгууллагад хандан шийдвэр гарсан 5.6 сая төгрөг байна.

- МХЭДХ-өөр 2016-2021 онд 220 иргэнд 1,008.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос 270.7 сая төгрөгийг 2016 онд 50 хувиар хөнгөлж, 660.8 сая төгрөгийг төвлөрүүлж, 213.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс гэрээний хугацаа дуусаагүй 212.2 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 0.8 сая төгрөг байна. Хугацаа хэтэрсэн үлдэгдэл 0.8 сая төгрөгийг төлүүлэхээр СТА-аар төлбөрийн акт тогтоосон байна.
- ХБИ-ийг дэмжих 2016-2021 онд 136 иргэнд 255.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос 39.0 сая төгрөгийг 2016 онд 100 хувиар хөнгөлж, 2020-2021 онд 106.0 сая төгрөгийг 50 хувиар хөнгөлж, 125.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 37.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс гэрээний хугацаа дуусаагүй 33.6 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 4.0 сая төгрөг байна. Хугацаа хэтэрсэн үлдэгдэл 1.2 сая төгрөгөөс төлүүлэхээр СТА-аар төлбөрийн акт тогтоосон ба 2.8 сая төгрөгийг төлүүлэхээр Шүүхийн шийдвэр гарсан байна.
- Ахмад настны ХЭДХ-өөр 2016-2021 онд 59 иргэнд 90.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос 70.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 20.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс гэрээний хугацаа дуусаагүй 19.9 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 0.5 сая төгрөг байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 0.4 сая төгрөгийг төлүүлэхээр СТА-аар төлбөрийн акт тогтоосон ба 0.1 сая төгрөгийг 2022 оны 2 сард төвлөрүүлсэн байна.
- ОНО хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг 2016-2021 онд 19 иргэнд 300.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос 238.5 сая төгрөгийг төвлөрүүлж, 61.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс гэрээний хугацаа дуусаагүй 53.1 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 8.3 сая төгрөг байна. Уг хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэхээр хуулийн байгууллагад хандсан байна.
- ЗХЭДХ-өөр 2016-2021 онд 41 иргэнд 234.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос 173.9 сая төгрөгийг төвлөрүүлж, 60.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эдгээр нь гэрээний хугацаа дуусаагүй үлдэгдэл байна.

Дүрслэл №5: Гэрээний хугацаа дууссан болон дуусаагүй санхүүгийн дэмжлэг /хувиар/



Дээрх дүрслэлээс харахад гэрээний хугацаа дууссан зээлийн нийт хөтөлбөрт эзлэх хувь 1-3 бага байгаа нь дараах шалтгаантай холбоотой гэж үзлээ. Үүнд:

- Аймгийн Төрийн аудитын газраас ХЭДС-ийн жил бүрийн СТА-г баталгаажуулах санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг иргэн тус бүрээр тооцоог хийж, 2018-2021 онд 37.9 сая төгрөгийн шийдвэрийг гарган ХХҮГ-т хүргүүлсэн байна. ХХҮГ шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах тал дээр санаачилгатай ажилласан нь сайшаалтай байна. Тухайлбал: Зарим хугацаа хэтэрсэн зээлдэгчийг Шүүхэд хандан шийдвэр гаргуулан ШШГА-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.

- Мөн цар тахалтай холбоотойгоор Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 03 дугаар тогтоол “Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хуваарийг хойшлуулах тухай” батлагдсанаар 2018, 2019 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 304 иргэн гэрээний хугацааг 6 сараас 2 жил хүртэл хугацаанд хойшлуулсан байна.

2.3.2. ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан боловч үр нөлөөг тооцоогүй байна.

Засгийн газраас 2011 оны 375 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг тус тус баталжээ. ХЭДС-ийн хөрөнгийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах, мэргэжлийн сургалтад хамруулах, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих, хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийг мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулдаг байна.

ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалт:

Аймгийн хэмжээнд ХЭДС-аас 2016 онд 567.9 сая төгрөгийг, 2017 онд 690.3 сая төгрөгийг, 2018 онд 837.2 сая төгрөгийг, 2019 онд 1,085.5 сая төгрөгийг, 2020 онд 541.0 сая төгрөгийг, 2021 онд 606.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан ба 2016-2021 онд зарцуулаагүй үлдэгдэл 2,181.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. /дэлгэрэнгүйг хавсралт № 6-аас үзнэ үү/

Хүснэгт № 8: Аймгийн ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалт /сая.төг/


	Төсөл, хөтөлбөр	2016	2017	2018	2019	2020	2021	дүн
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ	10.3	4.4	9.7	8.4	1.9	6.0	40.7
2	Ажилд зуучлах үйлчилгээ	2.1	1.9	2.3	6.7	2.1	1.3	16.6
3	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	134.9		-	-	-	-	135.0
4	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	11.7	16.6	13.3	12.8	12.0	6.0	72.4
5	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	56.7	306.3	228.5	415.3	322.5	239.0	1,568.3
6	Залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн ХЭД хөтөлбөр	20.2	32.9	67.2	162.7	0.6	18.0	301.7
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ХЭД хөтөлбөр	40.1	37.6	48.7	51.0	60.0	59.7	297.1
8	Малчдын ХЭД хөтөлбөр	260.3	185.0	208.0	220.0	75.3	97.1	1,045.6
9	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	7.6	21.5	28.2	33.6	41.5	37.9	170.3
10	Засгийн газар, ХЭ-ийн үндэсний зөвлөл бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт	0.6		1.5	-	-	-	2.1
11	Бусад зардал	23.1		28.0	66.7	25.3	51.1	233.8
12	Төвлөрүүлэх шилжүүлэг	69.7	232.0	410.7	411.1	471.1	587.1	2,181.8

13	Орон нутгийн онцлогт тохирсон төсөл хөтөлбөр			200.0	108.5	-	90.3	308.5
14	Өр барагдуулах		44.3				90.2	
15	Гэрээт малчин өрхийн санхүүжилт			1.9	-	-	-	1.9
	дүн	637.6	922.3	1,247.9	1,496.6	1,012.0	1,193.3	6,510.3

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг:

ХЭДС-аас 2016-2021 онд олгосон санхүүгийн дэмжлэгийн 31.7 хувийг АБДХ, 36.5 хувийг нь МХЭДХ, 10.8 хувийг ОНО-той зорилтот төсөл хөтөлбөр, 10.3 хувийг ХБИ-ий ХЭДХ, 3.3 хувийг ахмад настны ХЭДХ эзэлж байна. Эндээс дүгнэхэд малчдын ХЭДХ, АБДХ-т ихээхэн хэмжээний хөрөнгийг зарцуулсан нь харагдаж байна.

Дүрслэл №6: ХЭДС-аас 2016-2021 онд олгосон санхүүгийн дэмжлэг, хөтөлбөрөөр /сая.төг/



Тус хөтөлбөр нь аж ахуй бичил бизнес болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид санхүү, эдийн засгийн болон бусад дэмжлэг үзүүлэх замаар ажлын байрыг бий болгох зорилготой.

Санхүүгийн дэмжлэгт хамрагдах Есөнбулаг сумын хувиараа ах ахуй, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэд аймгийн ХХҮГ-т төслөө ирүүлэн ажлын хэсэг томилогдон сонгон шалгаруулалт хийгддэг бол сумдын иргэд амьжиргаа дэмжих зөвлөлөөр дамжуулан сонгон шалгаруулалт хийж материалыг ХХҮГ-т хүргүүлдэг байна.

ХЭДС-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтээ 2016 онд 191 иргэн, 2017 онд 170 иргэн, 2018 онд 241 иргэн, 2019 онд 242 иргэн, 2020 онд 118 иргэн, 2021 онд 120 иргэн ирүүлснээс 72.5 хувь нь хамрагдсан байна. /дэлгэрэнгүйг хавсралт №7-аас үзнэ үү/

Аудитаар бүх сумдын амьжиргаа дэмжих зөвлөлтэй хамтран, ХЭДС-аас 2016-2021 онд олгосон санхүүгийн дэмжлэгийг хамруулан хяналт хийсэн. Хяналтаар 2016-2021 онд санхүүгийн дэмжлэг авсан иргэд журмын дагуу сонгон шалгаруулалтад орсон эсэх, үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэх, шинээр ажлын байр нэмэгдүүлсэн эсэхэд дүгнэлт өгсөн.

Аудит хийх явцад сумдын амьжиргаа дэмжих зөвлөлийн 25 иргэн сонгон шалгаруулалтад ороогүй, 83 иргэн 444.3 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан буюу үйл ажиллагаа явуулаагүй байгаа, нийт төсөлд заасан 336 ажлын байрыг шинээр бий болоогүй байна гэж дүгнэлээ.

Мөн төслийг бодитоор нь хэрэгжүүлээгүй боловч зээлийн үндсэн төлбөр, хүү болох 342.2 сая төгрөгийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу хийсэн байна. /дэлгэрэнгүйг хавсралт № 8-оос үзнэ үү/

Зориулалт бус зарцуулалтыг хөтөлбөр тус бүрээр харуулбал:

- АБДХ-т 310 иргэн хамрагдсанаас 8 иргэн сонгон шалгаруулалтад ороогүй, 10 иргэн 16.4 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: Дарив-2, Дэлгэр-2, Жаргалан-1, Тайшир-1, Төгрөг-1, Чандмань-1, Шарга-2 сумууд байна.
- МХЭДХ-т 208 иргэн хамрагдсанаас 12 иргэн сонгон шалгаруулалтад ороогүй, 28 иргэн 126.4 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: Бигэр-1, Дэлгэр-1, Есөнбулаг-10, Жаргалан-1, Төгрөг-3, Хөхморьт-2, Цогт-3, Цээл-1, Шарга-1, Эрдэнэ-1 иргэн сумууд байна.
- ХБИ-ны ХЭДХ-т 136 иргэн хамрагдсанаас 3 иргэн сонгон шалгаруулалтад ороогүй, 10 иргэн 16.0 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: Бугат-1, Дарив-2, Жаргалан-1, Төгрөг-1, Цогт-2, Чандмань-2, Шарга-1 сумууд байна.
- Ахмад настны ХЭДХ-т хамрагдсан 59 иргэнээс 1 иргэн сонгон шалгаруулалтад ороогүй, 4 иргэн 6.5 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: Жаргалан-1, Цогт-2, Шарга-1 иргэн байна.
- ОНО-той төсөл хөтөлбөрт хамрагдсан 19 иргэнээс 7 иргэн 114.9 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: Алтай-1, Есөнбулаг-1, Жаргалан-1, Тайшир-1, Халиун-1, Цогт-1, Шарга-1 иргэн байна.
- ЗХЭДХ-т 41 иргэн хамрагдсанаас 1 иргэн сонгон шалгаруулалтад ороогүй, 24 иргэн 164 сая төгрөгийн зээлийг авсан боловч аудитын явцад зориулалт бусаар зарцуулсан Дарив-1, Дэлгэр-1, Есөнбулаг-18, Цогт-1, Чандмань-2, Шарга-1 иргэн байна.

Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.8-д “жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж заасан бөгөөд улирал тутам хяналт хийсэн гэх боловч үр дүнгүй, үйл ажиллагаа явуулаагүй байгаа иргэний санхүүгийн дэмжлэгийг эргэн төлүүлэх тал дээр санаачилга гаргаж ажиллаагүй байна.

Журамд зааснаар хөтөлбөрт хамрагдах 1 иргэнд санхүүгийн дэмжлэг олгох дээд хэмжээг 3 сая, 5 сая, 10 сая, 20 сая төгрөг хүртэл заасан бөгөөд 2016 онд буцалтгүй олгон, иргэн бүрийг хамруулах чиглэл барьж, төслийг 0.5, 0.7, 0.8, 1.0, 1.5, 2.0 сая төгрөгөөр хувааж олгосон нь төсөл хөтөлбөр хэрэгжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоо хангуулаагүй байна гэж үзлээ.

Аудитаар зарим төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцахад өрхийн үйлдвэрлэл эрхэлж, өөрсдийгөө ажлын байраар хангасан боловч Нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй, Татварын тайлан гаргадаггүй байна. Учир нь зээлийн хэмжээ бага байдгаас үйлдвэрийн ажлын байр худалдан авах, түрээслэх боломжгүй, шимтгэл, татвар төлөх боломжгүй байдаг байна.

Аудитаар орон нутгийн онцлогтой төсөл хөтөлбөр, залуучуудыг дэмжих чиглэлээр олгосон томоохон хэмжээний санхүүгийн дэмжлэгийг тайланд тодруулж орууллаа.

ОНО-той ТАХ-ны талаар:

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн тогтоол шийдвэрийн дагуу 2018 онд 12 иргэнд 200.0 сая төгрөг, 2019 онд 7 иргэнд 100.0 сая төгрөг нийт 299.9 сая төгрөгийг олгосон байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар “Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн зорилтот төсөл хэрэгжүүлэх тухай” тогтоолын 1 дүгээр хавсралтаар төслийн тэргүүлэх чиглэл, тавих ерөнхий шаардлага, шалгуур

үзүүлэлтийг тогтоосон. Гэвч орон нутгийн онцлогтой олгосон зээлүүд нь дараах шаардлагыг хангаагүй байна.

- Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс 2018 онд 12 иргэнд арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр олгохдоо татвар болон нийгмийн даатгалд өр төлбөргүй байх, ЖДҮДС, ХЭДС-ийн зээл дэмжлэгт хамрагдаагүй байх шалгууруудыг харгалзан үзээгүй, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөлөөр хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл үйлдээгүй байна. Мөн 12 иргэний төсөлд 30 ажлын байр шинээр бий болгохоор заасан боловч, бодит байдал дээр 5 ажлын байр шинээр бий болжээ. Төслийн эдийн засгийн үндэслэл тооцоолол үр ашгийг тооцоогүйгээс 6 иргэн буюу 50 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй, зогсонги байдалтай байна. Эдгээр нь Алтай, Жаргалан, Тайшир, Халиун, Цогт, Шарга сумдад байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс 2019 онд 7 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ тэргүүлэх ач холбогдолд тусгагдаагүй /хүнсний дэлгүүр, ажлын хувцас, рестораны үйл ажиллагаа явуулдаг/ 4 аж ахуй нэгж, иргэнд дэмжлэгийг олгосон байна. Эдгээрийн 1 нь салбар зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан бөгөөд 2018 онд арилжааны банкнаас 3 хувийн хүүтэй 20.0 сая төгрөгийн зээл, 2019 онд ХЭДС-аас ОНО-той төслийн 15.0 сая төгрөг, 2020 онд улсын ЖДҮС-аас 138.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд давхар хамрагдсан байна. Гэвч ажлын байр нэмэгдээгүй байна. Мөн онд орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн шалгуур үзүүлэлт, тэргүүлэх чиглэлийг харгалзан үзэхгүйгээр зээлийн өр төлбөртэй /СХС-аас 2018 онд 30.0 сая төгрөгийн зээл авсан/ 1 иргэнд 2019 онд 15.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Аудитаар 7 иргэний үйл ажиллагаатай танилцахад 1 иргэн Цогт сумын Баянтоорой тосгонд амьдардаг боловч хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлээгүй, зээлийг зориулалт бусаар зарцуулсан ба 7 иргэний төсөлд 16 ажлын байр шинээр бий болгохоор заасан боловч бодит байдал дээр 4 ажлын байр бий болжээ.

Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн олгосон санхүүгийн дэмжлэгийн 62 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа, 36 хувь буюу 6 иргэн үйл ажиллагаа явуулаагүй байна.

Төслийн эдийн засгийн үр ашгийг бодитой тооцоогүй, эргэн төлөлтийг хангуулах үүднээс тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй үйл ажиллагаа тогтвортой явуулж байгаа иргэн, ААНБ-д санхүүгийн дэмжлэгийг олгосон нь шинээр ажлын байр бий болгох зорилт хангагдаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлт хийгдээгүй байна. Энэ нь “Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд санхүүгийн дэмжлэг олгох гэрээ”-ний 3.3-т “төслөө хэрэгжүүлэх хугацаанд бусад иргэнийг тогтвортой ажлын байраар хангаж, хуулийн дагуу сайн дурын нийгмийн даатгал эсвэл заавал даатгалд хамруулна” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна гэж үзлээ.

ЗХЭДХ-ийн талаар:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 9 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар “Залуучуудын хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” батлагдсан бөгөөд 2017 оны 1 дүгээр тогтоол, 2021 оны 58 дугаар тогтоолуудаар шинэчлэгдэн батлагдсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 2017 онд 13 иргэнд 22.0 сая төгрөгийн, 2018 онд 14 иргэнд 54.0 сая төгрөгийн, 2019 онд 14 иргэнд 210.0 сая төгрөгийн нийт 286.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

Зураг 2: Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан, үйл ажиллагаа явуулж байгаа иргэд




- Тус хөтөлбөрийн хүрээнд 2016 онд МСҮТ-ийг төгссөн 13 төгсөгчдөд тус бүр 2-3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж худалдан авахад дэмжлэг болгон нийт 22.0 сая төгрөгийг олгожээ. Эдгээр залуучуудын үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхэд хяналт хийхэд 7 буюу 53 хувь нь үйл ажиллагаагаа явуулж ажлын байраа хадгалсан хэдий ч Нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй байна.
- Тус хөтөлбөрийн хүрээнд 2017 онд Залуучуудын гарааны бизнесийг дэмжихэд 3 бүлэг иргэнд 30.0 сая төгрөгийг олгосон байна. Аудитын хяналтаар дээрх төсөлд заасан үйл ажиллагаагаа явуулаагүй, ажлын байр огт нэмэгдүүлээгүй, ажил эрхэлж байгаа залуучууд байна. Мөн МСҮТ-ийг төгссөн 11 иргэний үйл ажиллагааг хянахад 45 хувь буюу 5 иргэн үйл ажиллагаа явуулаагүй байна.
- Тус хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 15 иргэнд 210.0 сая төгрөгийг олгосон бөгөөд аудитын хяналтаар 66 хувь буюу 10 иргэн үйл ажиллагаа явуулаагүй байна.

ЗХЭДХ-т 2016-2021 онд хамрагдсан 42 иргэний 59.5 хувь буюу 25 иргэн үйл ажиллагаа явуулаагүй зогсонги байдалтай, нийт төсөлд заасан 80 ажлын байрнаас 17 ажлын байр бий болсон боловч нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй байна. Энэ нь иргэнтэй байгуулсан гэрээний 3.7-д "төслийн үр дүнд байнгын ажлын шинэ байртай болж, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн байна", 3.9-д "Нийгмийн даатгалын сайн дурын эсвэл заавал даатгалд хамрагдсан байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Бусад дэмжих хөтөлбөрийн талаар:

- Нийтийг хамарсан ажил: Уг хөтөлбөрийн 2017 онд 151.6 сая төгрөгийг зарцуулж, 580 түр ажлын байрыг бий болгосон бол 2021 онд 55.9 сая төгрөгийг зарцуулж, 204 түр ажлын байрыг болгосон нь 2 дахин буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь цар тахалтай холбоотойгоор нийтийг хамарсан ажлыг түр зогсоосонтой холбоотой байна. Хөтөлбөрт хамрагдсан сумууд хог цэвэрлэгээ, цэцэрлэгжүүлэлт, шуудуу татах, ногоон орчин зүлэгжүүлэх, зам засвар, тохижилт, булаг шанд цэвэрлэгээ, худаг засварлах, мод тарих зэрэг ажлыг үр дүнтэй зохион байгуулсан байна.

Дүрслэл № 7: Нийтийг хамарсан ажлын хүрээнд бий болсон түр ажлын байр, зарцуулсан хөрөнгө, хамрагдсан сумаар /тоо, сая төгрөг, тоогоор/



- Бусад шууд зардал: ХЭДС-гаас үйл ажиллагаатай холбоотой 2016-2021 онд салбарын ажилтнуудын сургалтын зардалд 46.2 сая төгрөг, бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулахад 2016-2021 онд 28.3 сая төгрөг, хөтөлбөр төслийн хяналт, үнэлгээ хийхэд 45.1 сая төгрөг, сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад 25.7 сая төгрөг, хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн зардал 19.4 сая төгрөг, гарын авлага хэвлэмэл материалын зардалд 19.2 сая төгрөг, хүүхэд хамгаалагч төсөлд 5.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.4 Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан (МБСДС) болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөөг тооцох боломжгүй байна.

2.4.1 МБСДС-аас суралцагчдад тэтгэлэг олгодог болсноор сургууль завсардах, хичээл таслах асуудал буурсан байна.

Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас Говь-Алтай аймгийн Мэргэжлийн боловсрол сургалтын төвийн суралцагчдад 2019 онд 121.9 сая, 2020 онд 575.8 сая, 2021 онд 620.0 сая нийт 1,317.7 сая төгрөгийн тэтгэлгийг олгосон байна. 2019 онд давхардсан тоогоор 1219 суралцагч тэтгэлэг авахаас 1130 суралцагч тэтгэлэг авч, 89 сурагч чөлөө авсан, сургуулиас гарсан шалтгаанаар хасагдсан, 2020 онд давхардсан тоогоор 2879 суралцагч тэтгэлэг авахаас 2770 суралцагч тэтгэлэг авч, 109 сурагч чөлөө авсан, сургуулиас гарсан шалтгаанаар хасагдсан, 2021 онд давхардсан тоогоор 3100 суралцагч тэтгэлэг авахаас 3026 суралцагч тэтгэлэг авч, 74 сурагч чөлөө авсан, сургуулиас гарсан шалтгаанаар хасагдсан байна.

Холбогдох албан тушаалтантай ярилцлага хийхэд тэтгэмж олгодог болсноос хойш суралцагч сургууль завсардах нь багассан гэх тайлбарыг өгсөн.

2.4.2 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас олгосон санхүүжилтийн үр нөлөөг тооцох боломжгүй байна.

Аймгийн Мэргэжлийн боловсрол сургалтын төв болон төрийн байгууллагуудад тус сургуулийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны мэдээлэл, судалгаа байсангүй.

Харин аймгийн Засаг дарга Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдтай байгуулсан гэрээний биелэлтэд “Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа” бүлэгт 2016-2017 онд төгссөн хүүхдүүдийг ажил хайгчаар хөдөлмөрийн зах зээлийн LMIS системд бүртгэж сургалт хийсэн. МСҮТ-ийн 13 төгсөгчид 30.0 сая төгрөг олгож 15 ажлын байр бий болгосон, 2018 онд 9 төгсөгчид 22.0 сая төгрөг олгож 9 ажлын байр бий болгосон 2021 онд 235 суралцагчийг 120 аж ахуйн нэгжид гэрээ байгуулан үйлдвэрлэлийг зүгшрүүлэх болон төгсөлтийн өмнөх дадлагад хамруулж байгаа тухай дурдсан байна.

2.5 "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл холбогдох байгууллагуудад байхгүй байна.

2.5.1 Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хэрэгжсэн байна.

Говь-Алтай аймагт цар тахлын үед ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр 2020-2021 онд 88 иргэн, аж ахуйн нэгжид 2,344.9 сая төгрөгийн зээл олгосон байна.

Харин нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтөд 492 аж ахуй нэгж хамрагджээ.

Харин Улсын Их хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлд заасан ажлын байрыг хадгалах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээлэл аймгийн ЗДТГ болон холбогдох байгууллагуудад байсангүй.

2.5.2 Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна.

Аймгийн хэмжээнд 2019 онд 523 аж ахуйн нэгжид 3496 иргэн, 2020 онд 542 аж ахуйн нэгжид 3481 иргэн, 2021 онд 534 аж ахуйн нэгжид 3504 иргэн ажиллаж байна.¹²

Түүнчлэн 2020 оноос 2021 онд аж ахуйн нэгжийн тоо 8-аар буурсан байх боловч 2019 онтой харьцуулахад 2,1%, ажиллагсад 0,2%, цалин хөлс 19,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тус хугацаанд Засгийн газар, орон нутгаас авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүнтэй байгааг илтгэж байна.¹³

2.5.3 Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалахаар хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд 173 байнгын ажлын байр шинээр бий болсон байна.

Аймгийн хувьд ХААН банк нь 1 зээлдэгчид 5.0 сая төгрөг, Төрийн банк нь 20 зээлдэгчид 184.0 сая төгрөг, Хас банк нь 67 зээлдэгчид 2,155.9 сая төгрөгийн зээлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр зээл олгосон байх бөгөөд зээлдэгчид нь төслийг зориулалтын дагуу зарцуулан үйл ажиллагаа явуулж байна.

Зээлийн хэрэгжилтэд нь арилжааны банкууд хяналт тавьж байгаа бөгөөд хуваарийн дагуу эргэн төлөлтийг хийж, ажлын байрыг хадгалж байна.

Түүнчлэн ХЭДС-аас үйлдвэрлэл үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд нь чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг хувиараа хөдөлмөр эрхлэгч 35-аас дээш хөдөлмөрийн насны 33 иргэний төсөлд 120.0 сая төгрөгийг олгож 33 ажлын байр, 18-45 хүртэлх насны 200 хүртэл толгой малтай 14 сумын 20 малчин өрхийг 92.0 сая төгрөгөөр малжуулж 40 ажлын байр, 14 ахмадад 27.0 сая төгрөгийг ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хүрээнд олгож 14 ажлын байр, хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэнд 56.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 18 ажлын байр, Старт-ап хөтөлбөрийн хүрээнд 1 төсөлд 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж нийт 106 ажлын байрыг бий болгосон байна.¹⁴

2.5.4 Аймгийн хэмжээнд цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтийн талаар нэгдсэн судалгаа мэдээлэл байхгүй байна.

Тус хугацаанд хамаарах хөдөлмөрийн салбарын тоо мэдээ, статистик судалгааг авахаар аймгийн ЗДТГ-т албан бичгээр хүргүүлсэн боловч ирүүлсэн мэдээлэл ихээхэн

¹² Эх сурвалж: Хаан, Хас, Төрийн банкны мэдээлэл.

¹³ Эх сурвалж: аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн тайлан.

¹⁴ Эх сурвалж: аймгийн ХХҮГ-ын 2021 оны жилийн эцсийн тайлан.

зөрүүтэй, албан ёсны тайлан мэдээгүй байна. Тухайлбал 61 аж ахуйн нэгж 7.2 тэрбум, 556 иргэн 15.7 тэрбум төгрөгийн арилжааны банкны жилийн 3 хувийн хүүтэй зээлд хамрагдсан гэх боловч түүнийг нотолсон судалгаа тооцоо байхгүй, төрийн аудитын газарт банкнуудаас ирсэн мэдээллээс зөрүүтэй байна.

Санал асуулгын талаар:

Санал асуулгыг ажил хөдөлмөр эрхэлдэггүй 50 хүнээс авлаа.

- Нийт оролцогчдын 11 хүн буюу 22% нь 18-25 насны, 5 хүн буюу 10% нь 26-34 насны мөн 22 хүн буюу 44% нь 35-45 насны, 7 хүн буюу 14% нь 56-60 насны, 5 хүн буюу 10% нь 60-аас дээш насны хүн хамрагджээ.
- Нийт оролцогчдын 24 хүн буюу 48% нь эрэгтэй, 26 хүн буюу 52 хувь нь эмэгтэй хүн байна.
- “Та ажил хийх ямар оролдлого хийсэн бэ” гэсэн асуултад санал асуулгад оролцогчдын дийлэнх нь хувийн бизнес эхлүүлэх, оролдлого хийгээгүй гэсэн 2 хариултыг өгч 11 хүн ажлын зарын дагуу холбогдох, 2-3 хүн бусад асуултыг сонгожээ.
- “Та орон нутгийнхаа ажилгүй иргэдийн бүртгэлд бүртгүүлсэн үү” гэсэн асуултад 14 хүн буюу 28% нь тийм, 33 хүн буюу 66% нь үгүй, 3 хүн буюу 6% нь хариулаагүй байна.
- Таны өрхийн сарын орлого ямар эх үүсвэрээс бүрддэг вэ? гэсэн асуултад 34% нь гэр бүлийн гишүүдийн орлогоос, 8% нь халамжаас, 28% нь хүүхдийн
- Та төрөөс хэрэгжүүлж буй ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих арга хэмжээний талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ? гэж асуухад нийт оролцогчдын 18% нь баг хорооноос, 24% нь таньдаг хүнээс, 10% нь ТВ радио, 18% нь цахим орчноос, 12% нь мэдээлэл хангалтгүй
- Таны ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан юу вэ? гэсэн асуултад дийлэнх Ковид-19-ийн улмаас ажлын байргүй болсон
- Таны оршин суугаа газарт ажлын байрны олдоц хэр байна вэ гэсэн асуултад оролцогчдын 2% нь сайн, 26% нь дунд, 68% нь муу гэж хариулсан байна.
- Ажилд ороход ямар шаардлагыг түлхүү тавьдаг вэ гэсэн асуултад оролцогчдын 14% нь боловсролын зэрэг, 20% нь нас, 8% нь хүйс, 2% нь гадаад дүр төрх, 4% нь ур чадвар, 22% нь ажлын туршлага, мөн 22% нь бусад гэсэн шалтгааныг сонгосон байна.

Өмнөх шийдвэрийн талаар:

Аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийгдсэн. Аудитаар 568.7 сая төгрөгийн зөрчил илэрч, 19.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 548.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 0.5 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлэн, 101.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 8 санхүүгийн бус үр өгөөж бүртгэсэн байна. Аудитын шийдвэрийг хэрэгжүүлсэн боловч, зөрчил давтан гарсаар байгаа нь хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажиллаагүй байгааг харуулж байна.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ:

1. Аймгийн ИТХ, ЗДТГ, ХХҮГ-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрийг төлөвлөхдөө иргэний нийгмийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, судлаачийн оролцоо, судалгаа тооцооллыг хийсэн эсэх нь нотлох баримтаар дэмжигдэхгүй байна.

2. Аймгийн хэмжээнд 2016-2020 онд хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аас 4 төсөл арга хэмжээг баталсан боловч 3 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй, үр дүнг тооцоогүй байна.
3. ХЭДС-ийн эх үүсвэрийг сумдад хуваарилахдаа хүн ам, ажилгүйдэл, ядуурлын түвшин зэргийг харгалзан үзээгүй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, үр дүнгийн судалгааг хийгээгүй, сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх тал дээр санаачилгагүй ажилласан байна. Аймгийн ЗДТГ, ХХҮГ болон салбарын байгууллагууд нь уялдаа холбоогүй, түүнийг тайлагнах ажил хангалтгүй, цаасан суурьт нотлох баримтыг архивын нэгж болгодоггүй, мэдээллийн сан, баазгүй, хяналт шалгалт хийгээгүй.
4. Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем /LMIS/-ийн тайлан, мэдээ тоо баримт зөрүүтэй, тоо мэдээллийг үнэн зөв бүртгээгүй, ашиглалт хангалтгүй байна.
5. Аймгийн хэмжээнд 2016-2021 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 83 иргэн төсөлд заасан үйл ажиллагаа явуулаагүй, зээлийг зориулалт бусаар зарцуулсан ба 28 иргэнтэй холбоотой 96.1 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.
6. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн гишүүнээр 2016-2020 онд ажиллаж байсан 1 иргэнд орон нутгийн онцлогтой зорилтот төслийн шалгуурыг хангахгүйгээр 2019 онд санхүүжилт 15.0 сая төгрөгийн дэмжлэгийн олгосон байна.
7. ХЭДС-аас 2019 онд орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн шалгуур үзүүлэлт, тэргүүлэх чиглэлийг харгалзан үзэхгүйгээр зээлийн өр төлбөртэй /Сум хөгжүүлэх сангаас 2018 онд 30.0 сая төгрөгийн зээл авсан/ 1 иргэнд 2019 онд 15.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.
8. Орон нутгийн онцлогтой төсөл арга хэмжээг сонгон шалгаруулахдаа тэргүүлэх ач холбогдолд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулдаг 4 иргэнд 55.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон, 7 иргэнтэй холбоотой 115.0 сая төгрөгийн дэмжлэг авсан иргэд үйл ажиллагаа явуулаагүй байна
9. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 22 иргэнтэй холбоотой 141.5 сая төгрөгийн дэмжлэг авсан иргэд үйл ажиллагаа явуулаагүй байна.
10. Эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгийн гэрээг дүгнээгүй, хөтөлбөрийн үр дүнг тооцоогүй, төсөлд заасан ажлын байр бий болоогүй, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт хийгдэхгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2016, 2018-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ажлын тайлан, хурлын тэмдэглэл зэрэг цаасан нотлох баримтгүй, 2016-2021 онд 25 иргэнд санхүүгийн дэмжлэг олгохдоо амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлээгүй олгосон, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж байна.
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлж ажиллаагүй, холбогдох тооцоо судалгаа байхгүй байна. Төлбөрт 2019 онд 3.8 сая төгрөг, 2020 онд 3.6 сая төгрөг, 2021 онд 171.5 сая төгрөг, нийт 178.9 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.
12. Сум хөгжүүлэх сангаас төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй 8 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, 259 иргэн зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
13. Сум хөгжүүлэх сангаас олгосон 954 зээлдэгчийн төсөл арга хэмжээнд зааснаар 1099 ажлын байрыг шинээр бий болгохоос бодитоор 539 ажлын байр бий болсон боловч нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй байна.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙР
НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ЗОРИЛТ
ХАНГАГДААГҮЙ, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН ӨССӨН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА.**

Дээрх дүгнэлтэд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

Аудитаар 601.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1 саналыг УАГ-т уламжлан, 1 заалт зөвлөмж, 7 заалт зөрчил арилгах албан шаардлага албан шаардлагыг хүргүүллээ.

Санал уламжлах тухай:

Үндэсний аудитын газрын Гуравдугаар газрын дарга Д.Энхболд танаа:

1. Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системийг үйл ажиллагааг сайжруулж, үр дүнг тооцдог байх

Зөвлөмж:

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар танаа:

1. Төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэхдээ талуудын оролцоог хангаж тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж үр дүнг тооцож байх

Албан шаардлага:

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Л.Ариунтуяа нарт:

1. Сумдад ХЭДС-гийн хөрөнгийг хуваарилахдаа ажилгүйдэл, ядуурлын түвшинг харгалзан үзэж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг судалгаа тооцоонд үндэслэн хийж салбар байгууллагуудын уялдааг хангуулан баримт бичгийг журмын дагуу архивын нэгж болгож
2. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлэн илэрсэн зөрчлийг журмын дагуу шийдвэрлэх

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баттайван, аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Л.Ариунтуяа нарт:

1. Зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй иргэдийн үйл ажиллагаанд хяналт хийж, биелэлтийг 2022 оны 07 сарын 25-ны дотор ирүүлэх

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, Хөдөлмөрийн хэлтсийн дарга Х.Энхтайван, аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Л.Ариунтуяа нарт

1. Зээлийн давхардалд хяналт хийж, журмын дагуу шийдвэрлэх
2. ХЭДС-гийн төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлэн илэрсэн зөрчлийг журмын дагуу шийдвэрлэх


Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баттайван танаа:

1. Санхүүгийн дэмжлэг олгосон зээлийн гэрээний заалтын дагуу гэрээг дүгнэж, төсөл хөтөлбөрийн үр дүнг тооцох
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг хуулийн дагуу шийдвэрлэх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Холбогдох байгууллагын санал, түүнд өгсөн хариу тайлбар


(ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ)
МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 82093
Утас: 7048-4004, Факс: 7048-3360
2022.05.04 № *2581*
танай _____-ны № _____-т
АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ
"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Цаашид гарсан зөрчлийг арилгаж, дахин гаргахгүй байх талаар анхаарч ажиллах болно.
зөвлөх  Д.БАТБИЛЭГ

0001301563